**НИЙСЛЭЛИЙН**
**ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 14 өдөр Дугаар А/157 Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
Тамгын газрын эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 80,849,416.00 (наян сая найман зуун дөчин есөн мянга дөрвөн зуун арван зургаа) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар (Д.Төмөрбаатар)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 7 нэр төрлийн нийт 80,849,416.00 (наян сая найман зуун дөчин есөн мянга дөрвөн зуун арван зургаа) төгрөгийн үнэ бүхий нийтийн эзэмшлийн хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар (Д.Төмөрбаатар)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА М.БАЯРАА

1119282495 2576849

Тушаал-2021

11505000481

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын
даргын 2021 оны ...06. дугаар сарын ...14...-ны өдрийн
...... дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | Байгууллагын үнийн санал | НӨАУГ-ын мэргэжилтний дүгнэлт | ЭБХХХК-ын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийтийн эзэмшил | | | | | | | | | | | | | |
| 1 | Зам талбай /Саппоро үйлчилгээний төв/ | 9 | м2 | 3316 | 16,386.90 | 54,338,960.40 | 50,263,538.37 | 4,075,422.03 | эвдэрсэн. | актлах | 0 | 0 | |
| 2 | Замын хашлага / Саппоро үйлчилгээний төв/ | 9 | м | 210 | 8,457.80 | 1,776,138.00 | 1,776,138.00 | - | эвдэрсэн. | актлах | 0 | 0 | |
| 3 | Ногоон байгууламж /Саппоро үйлчилгээний төв/ | 9 | ш | 122.9 | 7,209.00 | 885,986.10 | 546,358.17 | 339,627.93 | Эвдэрч, ашиглах боломжгүй болсон | актлах | 0 | 0 | |
| 4 | Усан оргилуур / Саппоро үйлчилгээний төв/ | 9 | ш | 1 | 9,974,051.50 | 9,974,051.50 | 9,225,998.00 | 748,053.50 | эвдэрсэн. | актлах | 0 | 0 | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Хайс /Саппоро үйлчилгээний төв/ | 9 | м | 96 | 24,000.00 | 2,304,000.00 | 2,304,000.00 | - | Эвдэрч, ашиглах боломжгүй болсон | актлах | 0 | 0 | |
| 6 | Хогийн сав /Саппоро үйлчилгээний төв/ | 9 | ш | 2 | 240,000.00 | 480,000.00 | 444,000.00 | 36,000.00 | Эвдэрч, ашиглах боломжгүй болсон | актлах | 0 | 0 | |
| 7 | Цэцгийн мандал / Саппоро үйлчилгээний төв/ | 9 | багц | 12 | 924,190.00 | 11,090,280.00 | 10,258,509.00 | 831,771.00 | эвдэрсэн. | актлах | 0 | 0 | |
| хасах хөрөнгийн дүн | | | | | | **80,849,416.00** | **74,818,541.54** | **6,030,874.46** | | | | | |